



ТЭМДЭГЛЭЛ

Хэрэв та CMS-ээр дамжуулан бодолтоо илгээж чадахгүй тохиолдолд дараахыг хийнэ үү:

- Илгээх файлуудаа desktop дээр байрлах `submit_<task name>` (аль хэдийн үүсгэчихсэн байгаа) фолдэрт **олимпиад дуусахаас өмнө нь** байршуулсан байх ёстой.
 - Зөвхөн-гаралт төрлийн бодлогын хувьд таны файлууд `01.out`, `02.out`, ..., `10.out` нэртэй байх ёстой.
 - Бусад бодлогуудын хувьд **яг ганц** бодолтын файл тухайн фолдэрт байх ёстой.
- Багийн ахлагчаасаа хүсэлт гаргуулахыг хүснэ үү.

Хэрэв танд нэмэлт цаг өгөх ёстой гэж бодож байвал дараахыг хийнэ үү:

- Яаралтай өргөдөл (олимпиадын системээр эсвэл цаасаар) илгээнэ үү.
- Олимпиад дууссаны дараа суудлаасаа босч, бусад оролцогчтой ярилцаж болохгүй.

Бодлого бүр олимпиадын системээс татаж авч болохуйц багц хавсралттай байна.

Энд "зөвхөн-гаралт" төрлийн бодлого байгаа. Үүний хувьд:

- Багц хавсралт нь жишээ оролт болон тестүүдийн оролтууд байна. Тест болгон нь дэд бодлогод тооцогдоно.
- Та олон гаралтын файлуудыг zip файл болгон илгээх боломжтой. Ингэхийн тулд гаралтууд нь `?.out` хэлбэртэй байна. Энд `??` нь тестийн дугаарыг илтгэнэ (өөрөөр хэлбэл `03.out`).
- Та зөвхөн-гаралт бодлогын хувьд хамгийн ихдээ 100 удаа илгээлт хийж болно. Илгээлт болгоны хувьд та ямар ч гаралтын файлын олонлогийг нэг дор илгээж болох юм.

Бусад бодлогуудын хувьд:

- Багц хавсралт нь жишээ шалгагч, жишээ хэрэгжүүлэлт, жишээ тестүүд болон хөрвүүлэх командыг агуулна.
- Бодлого бүрийн хувьд хамгийн ихдээ 50 илгээлт хийж болох бөгөөд та илгээх болгонд яг ганц файлыг илгээнэ.
- Илгээж буй бодолтын файлын нэр нь бодлогын өгүүлбэр дэх толгойд байрлуулсан. Бодолт нь бодлогын өгүүлбэр дэх функцуудын тодорхойлолтын

дагуу хэрэгжүүлэлтийг хийсэн байна.

- Та нэмэлт функцуудыг чөлөөтэй нэмж болно.
- Таны бодолт хэзээ ч стандарт оролтоос уншиж, стандарт гаралтад хэвлэж эсвэл аливаа файльтай харьцаж болохгүй. Гэхдээ бодолт нь стандарт алдаа уруу хэвлэж болно.
- Таны бодолт системийн дуудлага хийх ёсгүй, **ялангуяа `exit()` эсвэл `System.exit()`**
- Бодолтоо жишээ шалгагчаар шалгахыг хүсвэл бодлогын өгүүлбэр дээрх оролтын хэлбэр болон хязгаарлалтуудыг мөрдөн ажиллуулах ёстой. Үгүй бол үл мэдэх үйл явц өрнөж болзошгүй юм.
- In sample grader inputs, every two consecutive tokens on a line are separated by a single space, unless another format is explicitly specified.
- Хэрэв та бодолтоо өөрийнхөө компьютер дээр ажиллуулах бол бид багц хавсралтанд байгаа хөрвүүлэх командыг ашиглахыг зөвлөж байна. Хэрэв ашиглахгүй гэвэл C++ дээр `-std=gnu++14` -г нэмэхээ мартуузай.

Журам

Бодлогын өгүүлбэрүүдэд дараах ерөнхий төрлүүдийн нэрсийг ашиглаж байгаа: `void`, `int`, `int64`, болон `int[]` (array).

Эдгээр төрлүүдийн нэрийг программын хэлнүүдэд дараах байдлаар хэрэгжүүлэлтэд ашиглана уу:

Хэл	<code>void</code>	<code>int</code>	<code>int64</code>	<code>int[]</code>	а массивын урт
C++	<code>void</code>	<code>int</code>	<code>long long</code>	<code>std::vector<int></code>	<code>a.size()</code>
Java	<code>void</code>	<code>int</code>	<code>long</code>	<code>int[]</code>	<code>a.length</code>

Хязгаарлалтууд

Бодлого	Хугацааны хязгаарлалт	Санах ойн хязгаарлалт
line	зөвхөн-гаралт	зөвхөн-гаралт
vision	1 sec	1024 MB
walk	4 sec	1024 MB